НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Нийслэлийн Багануур дүүргийн Татварын хэлтсийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

**Аудитын код:** НТАГ-2026/261/НА-СТА-ТШЗ

| | |
|---|---|
| Цахим хуудас: www.audit.mn<br>Улаанбаатар хот<br>2026 он | Дарга, Тэргүүлэх аудитор Г.Нандинжаргал<br>Утас: 70007734 Цахим хаяг: nandinjargalg@audit.gov.mn<br><br>Санхүүгийн аудит хариуцсан ахлах менежер Х.Түвшинбаяр<br>Утас: 327734 Цахим хаяг: tuvshinbayarkh@audit.gov.mn<br><br>Аудитын менежер: Д.Отгонбаяр<br>Утас: 315558 Цахим хаяг: otgonbayarda@audit.gov.mn<br><br>Ахлах аудитор: М.Ундармаа<br>Утас: 325093 Цахим хаяг: undarmaam@audit.gov.audit.gov.mn<br><br>Аудитор: Ө.Цог-Өрнөх<br>Утас: 325093 Цахим хаяг: tsog-urnukhu@audit.gov.mn |

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

**Агуулга**

**1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ ....2**
**2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ ....4**
**АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ ....9**
**6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ ....10**

**Товчилсон үгийн жагсаалт**

| | |
|---|---|
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| НА | Нотлох ажил |
| НТАГ | Нийслэл дэх Төрийн аудитын газар |
| СТА | Санхүүгийн тайлангийн аудит |
| ТШЗ | Төсвийн шууд захирагч |
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| ТБОНӨХБАҮХАтХ | Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль |

# 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
НИЙСЛЭЛ ДЭХ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,
Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар,
Утас:7000 7734, Факс: (976-11) 32 01 54
И-мэйл: ub@audit.gov.mn, Вэбсайт: www.audit.mn

2026.02.25 № 99

танай ________ -ны № ________ -т

НИЙСЛЭЛИЙН БАГАНУУР ДҮҮРГИЙН ТАТВАРЫН ХЭЛТСИЙН ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Д.МӨНГӨНЦЭЦЭГ ТАНАА

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Нийслэлийн Багануур дүүргийн Татварын хэлтсийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг**

Тус байгууллага нь Нийслэлийн төсвөөс санхүүжүүлж, Нийслэлийн Татварын газраас шилжүүлсэн 10.9 сая төгрөгийн эх үүсвэрийг татварын орлого бүрдүүлэх үйл ажиллагааны зардалд зарцуулжээ.

Санхүүгийн тайлангийн тухай болон аудитын тайлангийн тухай хэрэглэгчдийн анхаарал хандуулах, ач холбогдолтой зүйлийн талаар тодруулахад санхүүгийн тайланд толилуулаагүй асуудал гараагүй болно.

**Аудитын гол асуудал**

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

1426050115

**Бусад асуудал**

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 5 зорилтын хүрээнд 27 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, гүйцэтгэлийг 89.5 хувийн хэрэгжилттэй гэж тайлагнасан байна. Улс болон орон нутгийн төсөвт 31,047.3 сая төгрөгийн орлого төвлөрүүлэхээс 32,113.1 сая төгрөгийн орлого төвлөрүүлж, орлогын төлөвлөгөөг 3.4 хувиар давуулан биелүүлсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Г.НАНДИНЖАРГАЛ

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

*2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон*

*/төгрөгөөр/*

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **36,350,849.04** | **33,327,574.16** |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | **36,350,849.04** | **33,327,574.16** |
| **354** | **Хангамжийн материал** | **36,350,849.04** | **33,327,574.16** |
| 35410 | Бичиг хэргийн материал | 3,528,533.20 | 1,700,494.32 |
| 35420 | Аж ахуйн материал | 20,379,942.06 | 21,325,046.06 |
| 35430 | Сэлбэг хэрэгсэл | 279,200.00 | 279,200.00 |
| 35440 | Түлш, шатах тослох материал | 1,930,000.04 | 0.04 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 10,233,173.74 | 10,022,833.74 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **67,648,428.06** | **69,552,648.64** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | **67,648,428.06** | **69,552,648.64** |
| **392** | **Биет хөрөнгө** | **67,648,428.06** | **69,552,648.64** |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 31,915,375.80 | 31,915,375.80 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | -6,178,458.88 | -7,207,262.48 |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 18,000,000.00 | 18,000,000.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | -12,578,323.12 | -14,377,338.77 |
| 39205 | Машин тоног төхөөрөмж(компьютер) | 121,370,814.20 | 134,287,922.85 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | -87,038,694.82 | -94,792,767.99 |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 18,325,809.16 | 18,325,809.16 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | -16,168,094.28 | -16,599,089.93 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **103,999,277.10** | **102,880,222.80** |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | **0.00** | **1,277,567.00** |
| **41** | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | **0.00** | **1,277,567.00** |
| **413** | **Өглөг** | **0.00** | **1,277,567.00** |
| **4136** | **Бусад өглөг** | 0.00 | 1,277,567.00 |
| 41361 | Байгууллагад төлөх өглөг | 0.00 | 1,082,567.00 |
| 41362 | Хувь хүмүүст төлөх өглөг | 0.00 | 195,000.00 |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **103,999,277.10** | **101,602,655.80** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | **103,999,277.10** | **101,602,655.80** |
| **511** | **Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан** | 140,383,274.00 | 140,383,274.00 |
| 51101 | Өмч: - төрийн | 140,383,274.00 | 140,383,274.00 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | **-68,817,609.54** | **-71,214,230.84** |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | -59,879,123.14 | -68,817,609.54 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | -8,938,486.40 | -2,396,621.30 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 32,433,612.64 | 32,433,612.64 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **103,999,277.10** | **102,880,222.80** |

### 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

*2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон*

*/төгрөгөөр/*

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **847,505,200.00** | **908,607,694.26** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **12,160,000.00** | **20,861,894.26** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | **12,160,000.00** | **20,861,894.26** |
| 120017 | Үнэ төлбөргүй орсон орлого - Үндсэн хөрөнгө | 11,509,000.00 | 20,861,890.26 |

| | | | |
|---|---|---|---|
| 120018 | Үнэ төлбөргүй орсон орлого - Бараа материал | 651,000.00 | 4.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **835,345,200.00** | **887,745,800.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | **822,245,200.00** | **876,845,800.00** |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 822,245,200.00 | 876,845,800.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | **13,100,000.00** | **10,900,000.00** |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 13,100,000.00 | 10,900,000.00 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **856,443,686.40** | **911,004,315.56** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **856,443,686.40** | **911,004,315.56** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **795,632,186.69** | **821,802,460.04** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **621,859,514.00** | **653,753,856.80** |
| 210101 | Үндсэн цалин | 312,744,967.00 | 326,543,649.54 |
| 210102 | Нэмэгдэл | 161,936,772.00 | 164,686,532.26 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 32,730,000.00 | 43,354,000.00 |
| 210104 | Урамшуулал | 114,447,775.00 | 119,169,675.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **74,576,831.06** | **78,924,505.12** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 52,428,454.40 | 54,871,218.65 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 6,352,493.28 | 6,718,509.40 |
| 210203 | ҮОМШ өвчний даатгал | 3,083,846.80 | 3,282,694.91 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 2,542,407.47 | 2,810,416.58 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 10,169,629.11 | 11,241,665.58 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **32,123,844.00** | **32,123,844.00** |
| 210302 | Түлш, халаалт | 6,977,900.00 | 6,977,844.00 |
| 210304 | Байрны түрээс | 25,145,944.00 | 25,146,000.00 |
| 210305 | Ашиглалтын зардалд төлсөн /ТӨҮГ/ | | |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **14,044,397.93** | **15,543,700.44** |
| 210401 | Бичиг хэрэг | 5,191,305.00 | 5,864,018.90 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 4,124,359.00 | 3,830,000.00 |
| 210403 | Шуудан холбоо, интернэтийн төлбөр | 3,610,303.93 | 3,777,081.54 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 1,018,430.00 | 2,072,600.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | **3,680,000.00** | **3,592,800.00** |
| 210702 | Дотоод албан томилолт | 3,680,000.00 | 3,592,800.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **20,525,228.00** | **18,406,084.00** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 20,156,000.00 | 18,153,100.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 63,128.00 | 232,984.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношилгоо | 22,000.00 | 20,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **26,464,371.70** | **19,457,669.68** |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 2,500,000.00 | 500,000.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл хорогдлын зардал | 23,510,957.70 | 18,957,669.68 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **60,811,499.71** | **89,201,855.52** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **57,418,076.00** | **630,000.00** |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 5,420,000.00 | 630,000.00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | **3,393,423.71** | **88,571,855.52** |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 3,393,423.71 | 88,571,855.52 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **-8,938,486.40** | **-2,396,621.30** |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | -8,938,486.40 | -2,396,621.30 |

**2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан**
*2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон*

*/төгрөгөөр/*

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | | |
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)** | 835,345,200.00 | 887,745,800.00 |
| 110003 | Хөрөнгийн орлого | | |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | 835,345,200.00 | 887,745,800.00 |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 822,245,200.00 | 876,845,800.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 822,245,200.00 | 876,845,800.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 13,100,000.00 | 10,900,000.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 13,100,000.00 | 10,900,000.00 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | 834,795,300.00 | 887,745,800.00 |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 834,795,300.00 | 887,745,800.00 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 773,983,800.29 | 798,543,944.48 |
| **2101** | **Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил** | 621,859,514.00 | 653,538,718.80 |
| 210101 | Үндсэн цалин | 312,744,967.00 | 326,690,917.23 |
| 210102 | Нэмэгдэл | 140,002,881.00 | 164,555,823.57 |
| 210103 | Унаа хоолны Хөнгөлөлт | 34,633,027.00 | 43,210,000.00 |
| 210104 | Урамшуулал | 134,478,639.00 | 119,081,978.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 74,576,831.06 | 79,139,643.12 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 52,428,454.40 | 55,086,356.65 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 6,352,493.28 | 6,718,509.40 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 3,083,846.80 | 3,282,694.91 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 2,542,407.47 | 2,810,416.58 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 10,169,629.11 | 11,241,665.58 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 32,123,844.00 | 31,272,757.00 |
| 210302 | Түлш, халаалт | 6,977,900.00 | 6,184,257.00 |
| 210304 | Байрны түрээс | 25,145,944.00 | 25,088,500.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 14,887,383.23 | 11,543,941.56 |
| 210401 | Бичиг хэрэг | 4,098,020.00 | 3,970,500.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 6,054,359.00 | 1,900,000.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 3,593,904.23 | 3,749,241.56 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 1,041,100.00 | 1,924,200.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 3,680,000.00 | 3,592,800.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 3,680,000.00 | 3,592,800.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 21,965,228.00 | 18,956,084.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 21,596,000.00 | 18,703,100.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 63,128.00 | 232,984.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношилгоо | 22,000.00 | 20,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 2,500,000.00 | 500,000.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 2,500,000.00 | 500,000.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 60,811,499.71 | 89,201,855.52 |

| | | | |
|---|---|---|---|
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 57,418,076.00 | 630,000.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 5,420,000.00 | 630,000.00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 3,393,423.71 | 88,571,855.52 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 3,393,423.71 | 88,571,855.52 |

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

*2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон*

*/төгрөгөөр/*

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Бусад | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|---|---|
| C01 | 2023 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл | 140,383,274.00 | 32,433,612.64 | -59,879,123.14 | 0.00 | 112,937,763.50 |
| C03 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 140,383,274.00 | 32,433,612.64 | -59,879,123.14 | 0.00 | 112,937,763.50 |
| C07 | Тайлант үеийн үр дүн | 0.00 | 0.00 | -8,938,486.40 | 0.00 | -8,938,486.40 |
| C08 | 2024 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл | 140,383,274.00 | 32,433,612.64 | -68,817,609.54 | 0.00 | 103,999,277.10 |
| D01 | 2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл | 140,383,274.00 | 32,433,612.64 | -68,817,609.54 | 0.00 | 103,999,277.10 |
| D03 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 140,383,274.00 | 32,433,612.64 | -68,817,609.54 | 0.00 | 103,999,277.10 |
| D08 | Тайлант үеийн үр дүн | 0.00 | 0.00 | -2,396,621.30 | 0.00 | -2,396,621.30 |
| D09 | 2025 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл | 140,383,274.00 | 32,433,612.64 | -71,214,230.84 | 0.00 | 101,602,655.80 |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

*2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон*

*/төгрөгөөр/*

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Тайлант оны | | | |
|---|---|---|---|---|---|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Хувь |
| 2 | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 882,643,600.00 | 792,374,273.84 | 90,269,326.16 | 89.8 |
| 21 | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 882,643,600.00 | 792,374,273.84 | 90,269,326.16 | 89.8 |
| 210 | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 882,013,600.00 | 791,744,273.84 | 90,269,326.16 | 89.8 |
| 2101 | **Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил** | 724,287,600.00 | 653,538,718.80 | 70,748,881.20 | 90.2 |
| 210101 | Үндсэн цалин | 323,396,500.00 | 326,690,917.23 | -3,294,417.23 | 101 |
| 210102 | Нэмэгдэл | 181,104,300.00 | 164,555,823.57 | 16,548,476.43 | 90.9 |
| 210103 | Унаа хоолны Хөнгөлөлт | 50,726,500.00 | 43,210,000.00 | 7,516,500.00 | 85.2 |
| 210104 | Урамшуулал | 169,060,300.00 | 119,081,978.00 | 49,978,322.00 | 70.4 |
| 2102 | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 92,861,300.00 | 79,139,643.12 | 13,721,656.88 | 85.2 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 63,862,600.00 | 55,086,356.65 | 8,776,243.35 | 86.3 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 7,279,100.00 | 6,718,509.40 | 560,590.60 | 92.3 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 3,637,600.00 | 3,282,694.91 | 354,905.09 | 90.2 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 3,616,400.00 | 2,810,416.58 | 805,983.42 | 77.7 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 14,465,600.00 | 11,241,665.58 | 3,223,934.42 | 77.7 |
| 2103 | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 31,272,900.00 | 31,272,757.00 | 143.00 | 100 |
| 210302 | Түлш, халаалт | 6,184,400.00 | 6,184,257.00 | 143.00 | 100 |
| 210304 | Байрны түрээс | 25,088,500.00 | 25,088,500.00 | 0.00 | 100 |
| 2104 | **Хангамж, бараа материалын зардал** | 11,231,900.00 | 6,208,270.92 | 5,023,629.08 | 55.3 |
| 210401 | Бичиг хэрэг | 4,513,500.00 | 2,464,000.00 | 2,049,500.00 | 54.6 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 2,992,000.00 | 2,220,070.92 | 771,929.08 | 74.2 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 2,987,400.00 | 1,524,200.00 | 1,463,200.00 | 51.0 |
| 2107 | **Томилолт, зочны зардал** | 4,046,700.00 | 3,592,800.00 | 453,900.00 | 88.8 |
| 210702 | Дотоод албан томилолт | 4,046,700.00 | 3,592,800.00 | 453,900.00 | 88.8 |
| 2108 | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 17,813,200.00 | 17,492,084.00 | 321,116.00 | 98.2 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 17,274,100.00 | 17,239,100.00 | 35,000.00 | 99.8 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 233,000.00 | 232,984.00 | 16.00 | 100 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношилгоо | 22,000.00 | 20,000.00 | 2,000.00 | 90.9 |
| 2109 | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **500,000.00** | **500,000.00** | 0.00 | 100 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага | 500,000.00 | 500,000.00 | 0.00 | 100 |
| 213 | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **630,000.00** | **630,000.00** | 0.00 | 100 |
| 2132 | **Бусад урсгал шилжүүлэг** | **630,000.00** | **630,000.00** | 0.00 | 100 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 630,000.00 | 630,000.00 | 0.00 | 100 |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | **876,845,800.00** | **876,845,800.00** | 0.00 | 100 |
| 1310 | **УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | **876,845,800.00** | **876,845,800.00** | 0.00 | 100 |
| 131001 | Улсын төсвөөс санхүүжих | 876,845,800.00 | 876,845,800.00 | 0.00 | 100 |

### 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

*2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон*

***/төгрөгөөр/***

| Дансны код | Үзүүлэлт | Гүйцэтгэл |
|---|---|---|
| **I** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **10,900,000.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **10,900,000.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **6,799,670.64** |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **5,335,670.64** |
| 210401 | Бичиг хэрэг | 1,506,500.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 1,900,000.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,529,170.64 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 400,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **1,464,000.00** |
| **210801** | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 1,464,000.00 |

| | | |
|---|---|---|
| **213303** | Төвлөрүүлэх шилжүүлэг | 4,100,329.36 |
| **II** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | **10,900,000.00** |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | **10,900,000.00** |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 10,900,000.00 |

## АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 1,277.5 мянган төгрөгийн зөрчил илэрч зөвлөмж өглөө.

Нийт илрүүлсэн 1,277.5 мянган төгрөгийн залруулагдаагүй зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс бага тул “Өөрчлөлтгүй” дүгнэлт өглөө.

### Зөвлөмж

### Өглөгийн данстай холбоотой

*Илрүүлэлт-1:* Байгууллагад төлөх өглөг 1,082.5 мянган төгрөг, хувь хүнд төлөх өглөг 195.0 мянган төгрөг, нийт 1,277.5 мянган төгрөгийн өглөг үүсгэж ажилласан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д "*Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх*", 16 дугаар зүйлийн 16.5.2-т "*батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих*", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах;", 20.2.6 "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах; гэж заасантай тус тус нийцэхгүй, санхүүгийн тайлагналын “эрх ба үүрэг” мэдэгдлийг хангахгүй байна.

*Өгсөн зөвлөмж:* Санхүүгийн өдөр тутмын үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллах, өр төлбөр үүсгэхгүй байх.

Дээрх зөвлөмжүүдийн биелэлтийг Нийслэл дэх Төрийн аудитын газарт 2026 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
| Байгууллагад төлөх өглөг 1,082,567 төгрөг, хувь хүнд төлөх өглөг 195,000 төгрөг, нийт 1,277,567 төгрөгийн өглөг үүссэн. | 1 | 1,277.5 | | | | | 1 | 1,277.5 | | | | |
| **Дүн** | 1 | 1,277.5 | | | | | 1 | 1,277.5 | | - | - | - |

### Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
| Нэмэлт санхүүжилттэй холбоотой зөрчил | | | | | | | | | | | | |
| Орон нутгийн төсвөөс үндсэн чиг үүргээ хэрэгжүүлэх санхүүжилтийг давхардуулан авч зарцуулсан. | 1 | 6,799.7 | - | - | - | - | 1 | 6,799.7 | - | - | - | - |
| Дүн | 1 | 6,799.7 | - | - | - | - | 1 | 6,799.7 | - | - | - | - |